



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 20 нэрийн нийт 273,885,023.79 (хоёр зуун далан гурван сая найман зуун наян таван мянга хорин гурван төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 272,726,878.08 (хоёр зуун далан хоёр сая долоон зуун хорин зургаан мянга найман зуун далан найман төгрөг найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, худалдах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Акталж данснаас хассан хуваарилах байгууламжийн доорх газрыг компанийн мэдэлд хэвээр үлдээж, нөхөн сэргээх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн
334 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтан д орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ	Хуримтлагдсан Элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Тоолуур DN20	2011/11/01	4	975,000.00	3,900,000.00	3,673,542.12	226,457.88
2	Тоолуур DN25	2011/11/01	2	1,450,000.00	2,900,000.00	2,755,819.22	144,180.78
3	Тоолуур DN40	2012/05/03	7	1,820,000.00	12,740,000.00	12,106,635.31	633,364.69
4	Тоолуур DN80	2012/05/03	1	3,100,000.00	3,100,000.00	2,945,857.64	154,142.36
5	Зарцуулалтын хэмжүүр	2012/01/01	6	11,163,901.61	66,983,409.66	66,983,409.66	0.00
6	Шилэн кабель төгсгөлийн техөөрөмжийн хамт /1,2км урт/	2011/11/01	1	15,829,944.00	15,829,944.00	15,829,944.00	0.00
7	Насос станцуудын дохиололын систем /IP camera/	2011/11/01	9	4,614,961.33	41,534,651.97	41,534,651.97	0.00
8	Гар станц	2012/05/03	30	303,136.36	9,094,090.80	9,094,090.80	0.00
9	Зөөврийн станц	2012/05/03	1	5,949,545.45	5,949,545.45	5,949,545.45	0.00
10	Гар станцын тог баригч	2012/05/03	1	7,229,090.91	7,229,090.91	7,229,090.91	0.00
11	ТА-6698H камер	2011/03/31	1	3,414,300.00	3,414,300.00	3,414,300.00	0.00
12	Насос 3-р станцын тоноглол, хувиарлах байгууламж	1989/01/01	1	34,898,873.00	34,898,873.00	34,898,873.00	0.00
13	Насос 1-р станцын хувиарлах байгууламж	1987/01/01	1	4,364,950.00	4,364,950.00	4,364,950.00	0.00
14	Насос1-р станцын бусад тоноглол	1987/01/01	1	1,866,888.00	1,866,888.00	1,866,888.00	0.00
15	Насос 6-р станцын хөдөлгүүр	1987/01/01	1	144,000.00	144,000.00	144,000.00	0.00
16	Насос 6-р станцын бусад тоноглол	1992/01/01	1	3,696,480.00	3,696,480.00	3,696,480.00	0.00
17	Ваакум таслуур	2004/01/01	1	50,494,700.00	50,494,700.00	50,494,700.00	0.00
18	Насос	1994/01/01	1	144,000.00	144,000.00	144,000.00	0.00
19	Насос	1994/01/01	1	145,600.00	145,600.00	145,600.00	0.00

20	Зөврийн насос	2007/01/01	1	5,454,500.00	5,454,500.00	5,454,500.00	0.00
				273,885,023.79	272,726,878.08	1,158,145.71	
НИЙТ ДҮН				(хоёр зуун далан гурван сая найман зуун наян таван мянга хорин гурван төгрөг далан есөн мөнгө)	(хоёр зуун далан хоёр сая долоон зуун хорин зургаан мянга найман зуун далан найман төгрөг найман мөнгө)	(нэг сая нэг зуун тавин найман мянга нэг зуун дөчин таван төгрөг далан нэгэн мөнгө)	